



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/288

Чингис хот

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах Хүдрийн биет 16-3 нэртэй MV-010646 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Монфайненс ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг Монфайненс ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/, Дархан сумын Засаг дарга /Ж.Энхтөр/ нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/-т тус тус үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



Аймгийн Засаг даргын 2020 оны
...06... дугаар сарын...12... өдрийн А/ЗС...
дугаар захирамжийн хавсралт



Монфайненс ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн
агуулахын газрын байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	46	18	15.10	109	24	17.01
2	46	18	15.56	109	24	21.21
3	46	18	12.31	109	24	21.69
4	46	18	11.92	109	24	17.55